



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/57

Хажуу шинэ-Ус

Малчдын зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улс Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 24 дүгээр тогтоол, Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.3.2, 3.1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчдын зөвлөгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсугай.

2. Малчдад тов хүргэж, мэдээлэх ажлыг Ажирхай багийн Засаг дарга (Б.Мөнхдэлгэр), Морьт багийн Засаг дарга (М.Амарзаяа), Хонгор багийн Засаг дарга (Н.Энхтайван), Өрнөлт багийн Засаг дарга (Л.Батбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Зөвлөгөөн сургалт арга хэмжээнд шаардагдах зардлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гарган зарцуулахыг Сан хариуцсан нягтлан бодогч (Э.Уранбилэг)-т даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

5. Малчдын зөвлөгөөний бэлтгэл ажлыг сайтар ханган малчид иргэдийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Даваасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401057